



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Ажилчдын ээлж солих тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Улсын Онцгой Комиссын ажиллах журмын 2.1.1, 2.1.2 дахь заалт, Засгийн газрын 194 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолын 10, 11 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч, ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн олборлогч, экспортлогч, тэдгээрийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажилчдыг коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, шинжилгээ өгөх нөхцлийг бүрдүүлж, ээлж солих ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Зам тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт тус тус даалгасугай.

2. Ээлжээс буух болон ээлжид гарах ажилчдыг шинжилгээнд бүрэн хамруулж, шинжилгээний хариуг үндэслэн Улаанбаатар хот болон орон нутагт саадгүй нэвтрүүлэх, гэрийн нөхцөлд 14 хоног тусгаарлан халдваргүйжүүлэлт, ариутгалын дэглэм сахиулахыг бүх шатны Онцгой комисст үүрэг болгосугай.

3. Ээлжинд гарах ажилчдыг ээлжээс бууж буй ажилчид, орон нутгийн иргэдтэй хавьтал үүсгэхгүйгээр халдваргүйжүүлэлт, ариутгалын дэглэмийг сахиулж тээвэрлэн уурхайд хүргэх, тэдгээрийг шууд ажиллах нөхцлийг бүрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай.

ДАРГА



Я.СОДБААТАР